**БНМАУ**

**УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН**
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ**

1991 оны 01 сарын 31 — №36. — Улаанбаатар хот

Газар байгуулах тухай

БНМАУ-ын Засгийн газрын шийдвэр, хотын захиргааны гишүүдийн 1991 оны I дүгээр сарын 31-ний өдрийн хурлын протоколыг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

I.Хотын эдэлбэр газрыг үнэлэх түрээсийн төлбөр тогтоох, хураах, барилга байгууламжийг үнэлэх, дахин үнэлэх, худалдах, түрээсээр ашиглуулах, албан ажлын байрны зохицуулалт хийх ажил хариуцсан Өмчийн газрыг 1991 оны 2 дугаар сарын I-ний өдрөөс эхлэн аж ахуйн тооцооны үндсэн дээр Хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дэргэд ажиллуулахаар байгуулсугай.

2.Хотын өмчийн газрын сарын цалингийн санг 16I00 төгрөгөөр баталсугай.

3.Хотын Өмчийн газрын ашиглалтын өмнөх зардалд зориулан I00,0 мянган төгрөгийг хотын төсвийн хийцэгдлээс шилжүүлэхийг Санхүүгийн газар /н.Гонгор/-т даалгасугай.

4.Хотын өмчийн газрын дүрмийг 2 дугаар сарын I5-ны дотор захиргаанд оруулж батлуулахыг Газрын дарга н.Найданд даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА — Л.ЭНЭБИШ

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА — Ч.СУМААХҮҮ